

ДОРНОД АЙМАГ ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2023-2024  
ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 6 ДУГААР АНГИЙН МХБУЗ-ЫН ХИЧЭЭЛИЙН  
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

ХУГАЦАА: 60 МИН

**ХУВИЛБАР А**

НИЙТ: 20 ОНОО

Эхийг уншаад утгыг ойлгон даалгаврыг гүйцэтгэнэ үү?

Ч.Лувсанжав

Сүх хүү

Сүх өглөө эртлэн босно.Тэгээд ээждээ зомгол түүж авчирч өгөх буюу хусны үйс хуулан галаа асаахад нь тусална. Тэгэхэд ээж нь баярлан хүүгийнхээ зулайг илнэ. Шөмбөгөрхөн нүүртэй, эелдэгхэн зантай, хүрэн бор царайтай Сүх хүү өдөр бүр хоёр бор авдрынхаа дундах модон шургуулган дээрх модон морь гүнгэрваа бүхий “Дарь эх” бурхныг гялалзтал арчина. Тэгснээ хэдэн модон тагшаа угааж өрж тавина.

Нэг өдөр ээжийнхээ цай уудаг шаазанг угааж байгаад хагалчхав. Сүх хүү “Яана даа! Ээжийн минь цай уудаг ганц шаазан” гэж харуусан бодохын зуур, бяцхан хар нүдийг нь нулимс бүрхэн хэрхэх учраа олохгүй хий л сандарна. Тэгээд ээжийнхээ үйлний гурилаас хагархайд нь түрхэн нийлүүлбэл дорхноо салж ойчлоо. Ээж нь орж ирэв.

- Ээж ээ! Та намайг бүү аашлаарай, би хэрэг хийсэн гэлээ. Миний хүү ямар хэрэг хийснээ хэл, ээж нь сонсьё гэхэд Сүх,

- Таны цай уудаг шаазанг угааж байгаад тулган дээр алдаад хагалчихлаа яана аа? гэж үнэнээ хэлэв.

Ээж нь, за яах вэ, миний хүү бүү сэтгэл зов. Шаазан олдоно биз! Үнэнээ хэлсэн чинь сайн байна. “Үнэнээр явахад үхэр тэргээр туулай гүйцнэ” гэдэг юм гэлээ. Ээжийгээ харахад хөрслөг бор нүүр нь туяаран, нэг л өнгө орсон юм шиг баяр жавхаа тодрон гэрэлтэж байлаа.

**Гүйцэтгэх даалгавар**

1. Ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас үгийн утга үүргийг тайлбарлана уу? 2 оноо  
Зомгол - утга.....

Үүрэг.....

2. “Сүх хүү өдөр бүр ээждээ тусална” гэсэн өгүүлбэрээс цөм өгүүлбэрийг ялгаж бичээд тодорхойлоорой. 2 оноо

3. Сүх өглөө эртлэн босдог гэсэн өгүүлбэрийг одоо ба өнгөрсөн цагийн утгатай болгон хувирган бичээрэй. 2 оноо

Одоо цагийн утга:.....

Өнгөрсөн цагийн утга:.....

4. Зохиогчийн дэвшүүлсэн асуудал, гол санааг тодорхойлон бичээрэй. 2 оноо

.....

.....

5. “тавина, авдрын” гэсэн үгийн зөв бичих дүрмийг тайлбарлан бичээрэй. 2 оноо

.....

.....  
 6. Энэхүү шүлгээр юуг ойлгуулахыг зорьсон бэ? Ухаарч ойлгосон өөрийн санаагаа 20-25 үгэнд багтаан бичнэ үү? 5 оноо

Өсөхийн цагт санууштай нь      Бишрэл хичээл сэтгэл гурав  
 Өөдлөхийн тулд нягтлууштай нь      Сургаал үнэн үлгэр гурав  
 Ачлахын дээдээр ачлууштай нь      Ээж аав эх орон гурав

.....  
 .....  
 .....  
 .....

7. Монгол бичиг 5 оноо

Сүхэ хүү нигэ эдүр эжи-ийн-ийэн айаг-а-йи унагажу хагалугсан. Мину хүү бүү сэдхил зоба. Эжи ни Сүхэ хүү-ийн зулаи-йи илибэ.

|  |  |  |  |  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|
|  |  |  |  |  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|

| Даалгавар        | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | Нийт оноо | хувь | Түвшин |
|------------------|---|---|---|---|---|---|---|-----------|------|--------|
| Авбал зохих Оноо | 2 | 2 | 2 | 2 | 2 | 5 | 5 | 20        |      |        |
| Авсан оноо       |   |   |   |   |   |   |   |           |      |        |

ДОРНОД АЙМАГ ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 6 ДУГААР АНГИЙН МХБУЗ-ЫН ХИЧЭЭЛИЙН

АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

ХУГАЦАА: 60 МИН

НИЙТ: 20 ОНОО

Эхийг уншаад утгыг ойлгон даалгаврыг гүйцэтгэнэ үү?

Ч.Лувсанжав

Сүх хүү

Сүх өглөө эртлэн босно.Тэгээд ээждээ зомгол түүж авчирч өгөх буюу хусны үйс хуулан галаа асаахад нь тусална. Тэгэхэд ээж нь баярлан хүүгийнхээ зулайг илнэ. Шөмбөгөрхөн нүүртэй, эелдэгхэн зантай, хүрэн бор царайтай Сүх хүү өдөр бүр хоёр бор авдрынхаа дундах модон шургуулган дээрх модон морь, гүнгэрваа бүхий “Дарь эх” бурхныг гялалзтал арчина. Тэгснээ хэдэн модон тагшаа угааж өрж тавина.

Нэг өдөр ээжийнхээ цай уудаг шаазанг угааж байгаад хагалчхав. Сүх хүү “Яана даа! Ээжийн минь цай уудаг ганц шаазан” гэж харуусан бодохын зуур, бяцхан хар нүдийг нь нулимс бүрхэн хэрхэх учраа олохгүй хий л сандарна. Тэгээд ээжийнхээ үйлний гурилаас хагархайд нь түрхэн нийлүүлбэл дорхноо салж ойчлоо. Ээж нь орж ирэв.

- Ээж ээ! Та намайг бүү аашлаарай, би хэрэг хийсэн гэлээ. Миний хүү ямар хэрэг хийснээ хэл, ээж нь сонсьё гэхэд Сүх,

- Таны цай уудаг шаазанг угааж байгаад тулган дээр алдаад хагалчихлаа яана аа? Гэж үнэнээ хэлэв.

Ээж нь, за яах вэ, миний хүү бүү сэтгэл зов. Шаазан олдоно биз! Үнэнээ хэлсэн чинь сайн байна. “Үнэнээр явахад үхэр тэргээр туулай гүйцнэ” гэдэг юм гэлээ. Ээжийгээ харахад хөрслөг бор нүүр нь туяаран, нэг л өнгө орсон юм шиг баяр жавхаа тодрон гэрэлтэж байлаа.

Гүйцэтгэх даалгавар

1. Ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас үгийн утга үүргийг тайлбарлана уу? 2 оноо “**тагш**” утга.....

Үүрэг.....

2. “**Ээж нь хусны үйсээр галаа асаана**” гэсэн өгүүлбэрээс цөм өгүүлбэрийг ялгаж бичээд тодорхойлоорой. 2 оноо

.....

3. “**Бяцхан хар нүдийг нь нулимс бүрхсэн**” гэсэн өгүүлбэрийг одоо ба өнгөрсөн цагийн утгатай болгон хувирган бичээрэй. 2 оноо

Одоо цагийн утга:.....

Өнгөрсөн цагийн утга:.....

4. Эхийн дэвшүүлсэн асуудлыг тодорхойлж, гол санааг хэлц үгээр илэрхийлээрэй. 2 оноо

.....

.....

5. “сонсьё, бурхныг” гэсэн үгийн зөв бичих дүрмийг тайлбарлан бичээрэй. 2 оноо

.....

.....

6. Энэхүү шүлэгт зохиолч юуны тухай бичихийг зорьсон бэ? Өөрийн бодол санаагаа 20-25 үгэнд багтаан илэрхийлэн бичнэ үү? 5 оноо

Монголын үзэсгэлэнт сарангоо намайг төрүүлсэн эжий

Яруу сайхан эгшгээрээ бөн бөн бүүвэйлсэн эжий

Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн эжий

Зүйтэй уран үгсээрээ сурган хүмүүжүүлсэн эжий

.....

.....

.....

.....

7. Монгол бичиг 5оноо

Сүхэ эдүр бүри эжи - дү –бэн тусалажу модун-у зомгол тэгүдэг. Модун тагси- бан өрүжү талбина. Эжи ни хүү –йин-ийн зулаи-йи илин-э. (20 үг)

|  |  |  |  |  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|
|  |  |  |  |  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|

| Даалгавар        | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | Нийт Оноо | хувь | түвшин |
|------------------|---|---|---|---|---|---|---|-----------|------|--------|
| Авбал зохих Оноо | 2 | 2 | 2 | 2 | 2 | 5 | 5 | 20        |      |        |
| Авсан оноо       |   |   |   |   |   |   |   |           |      |        |

Шалгасан багшийн нэр, гарын үсэг...../

/

